

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Огноо : 2026 оны 06 дугаар сарын 04

Сонгон шалгаруулалт шалгаруулалтын нэр: **Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-022859 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Даваатын алтны шороон ордод бүтээгдэхүүн хуваах зарчмаар хамтран ажиллах**

Эрдэнэс критикал минералс ТӨҮГ нь эрх бүхий оролцогчдоос бүтээгдэхүүн хуваах зарчмаар хамтран ажиллах ажлыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн санал ирүүлэхийг урьж байна.

Оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **2023, 2024, 2025 оны аль нэг жилийн** борлуулалтын орлогын хэмжээ нь **25 тэрбум төгрөгөөс багагүй байх.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **15 тэрбум төгрөгөөс багагүй байх ба харилцагч банкнаас тодорхойлолт авах тохиолдолд уг сонгон шалгаруулалт ялсан тохиолдолд зээл олгох боломжтой байна гэсэн утга бүхий Захиалагчид гаргасан банкны тодорхойлолтыг шаардлага хангасан материал гэж үзнэ.**

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **2023, 2024, 2025 оны аудитлагдсан тайлан ирүүлнэ.**

Ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: **Сүүлийн 3 жил буюу 2023, 2024, 2025 онуудын аль нэг жилд** гүйцэтгэсэн ижил төстэй ажлын үнийн дүн 20 тэрбум төгрөгөөс багагүй байх. Ижил төстэй ажил гэдэгт уул уурхайн ашиглалт, алтны шороон ордын олборлолтын чиглэлээр ажиллаж байсан гэж ойлгох бөгөөд тухайн ажлыг гүйцэтгэж байсан туршлага, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон гэрээ, гэрээ дүгнэсэн акт эсхүл өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт шаардлагатай.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Тийм, ААН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээнд Уул уурхайн олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрх бүхий тэмдэглэлтэй байх. Үүнд: уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа эрхлэх, уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх гэсэн чиглэлүүд хамаарах ба сонгон шалгаруулалт зарласан өдрөөс өмнөх огноотой байна.**

Саналыг 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй аж ахуйн нэгжийн эрх бүхий эсхүл итгэмжлэгдсэн оролцогчдыг байлцуулан сонгон шалгаруулалтыг 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 10 цаг 10 минутад нээнэ.

Гадаадын хуулийн этгээд санал ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: Эрхгүй

Сонгон шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлт хүлээн авах болон баримт бичгийг оролцогчид олгох хугацаа нь саналыг нээхээс хуанлийн 5 хоногоос багагүй байна.

Сонгон шалгаруулалтын баримт бичгийг авахдаа сонирхогч этгээд нь албан тоотоор хүсэлт гаргах ба урилгад дурдсан mailbox@ecmm.mn цахим хаягаар ирүүлснээр хариу хүргүүлнэ.

Улаанбаатар хот 51, ш/х – 002

Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө. 22-р хороо,
“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ийн байр, 505 тоот өрөө,

И-мейл: mailbox@ecmm.mn.

Утас/факс: 976-11-458380(ф), 976-11-450060-255,